



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 10 дугаар сар


Ерөнхий тойм: Оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 8.4%-иар буюу 595.4 сая ам.доллараар буурч 6494.6 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 5.1%-иар буюу 200.5 сая ам.доллараар, импорт 12.5%-иар буюу 394.9 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 957.7 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 194.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 10 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,544)	-23.1%	9,079	7,090	6,494.6	(1,989)	-21.9%	(595)	-8.4%
Экспорт	4,269	5,774	4,669	1505	35.3%	(1,105)	-19.1%	4,605	3,927	3,726	(678)	-14.7%	(201)	-5.1%
Импорт	6,358	5,237	3,797	(121)	-17.6%	(1440)	-27.5%	4,474	3,163	2,768	(1311)	-29.3%	(395)	-12.5%
Тэнцэл	(2,089)	538	872	2,626		335	62.2%	130	763	957.7	633		194	25.5%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь хүчин зүйлүүдийн нэг юм. Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2016 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1023.3 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 15.7 сая ам.доллараар өссөн байна.

Дүрслэл 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60.7% буюу 3944.5 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.3% буюу 731.5 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 10.8%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 18.8%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.10 сар	2016.9 сар	2016.10 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0.75	0.69	0.73	-3%	5%
Зэсийн баяж мал	0.36	0.30	0.32	-13%	6.2%
Чулуун нүүрс	0.41	0.40	0.44	7%	10.6%
Ямааны угаасан ноолуур	0.35	0.32	0.31	-13%	-3.7%
Импорт	0.54	0.58	0.57	5%	-2%
Хэрэглээний бараа	0.74	0.77	0.73	-1%	-5%
Хөрөнгө оруулалтын бараа	0.44	0.51	0.52	19%	3%
Нефтийн бүтээгдэхүүн	0.52	0.51	0.49	-6%	-3%
Худалдааны нөхцөл	1.38	1.20	1.28	-7.3%	7%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 7.3%-иар буурсан бол, өмнөх сараас 6.7%-иар өсч 1.283-д хүрлээ. Тайлант сард хэрэглээний барааны импортын үнэ буурсан, зэсийн баяжмал, нүүрсний экспортын үнэ өссөнөөс худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирсан байна.

Экспорт 2016 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 5.1%-иар буюу 200.5 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 2.4 нэгж хувиар өсөхөд нөлөөлсөн бол уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 6.7 нэгж хувиар буурахад нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2.4 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 2.7 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
I. Уул уурхай		4,095	89%		3,433	87%		3,169	85%	(663)	-16%	-14%	(264)	-8%	-7%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,095	1,932	42%	1,205	1,890	48%	1,321	1,393	37%	(42)	-2%	-1%	(496)	-26%	-13%
1.2. Чулуун нүүрс	14,839	683	15%	11,542	468	12%	18,557	605	16%	(216)	-32%	-5%	138	29%	4%
1.3. Боловсруулаагүй нефть	5,710	555	12%	6,618	328	8%	6,564	269	7%	(227)	-41%	-5%	(59)	-18%	-2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	4,997	367	8%	3,975	187	5%	5,332	209	6%	(180)	-49%	-4%	22	12%	1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	7,926	324	7%	9,474	357	9%	10,955	445	12%	33	10%	1%	88	25%	2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	87	98	2%	83	100	3%	106	117	3%	2	2%	0%	17	17%	0%
1.7. Жоунш, лейцит, нефелинт	258	59	1%	232	55	1%	207	50	1%	(4)	-7%	0%	(4)	-8%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	26	1%	4	25	1%	4	20	1%	(2)	-7%	0%	(5)	-20%	0%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	1	15	0%	1	12	0%	1	9	0%	(3)	-21%	0%	(3)	-26%	0%
1.10. Мөнгө /тонн/	42	33	1%	54	10	0%	79	34	1%	(22)	0%	0%	24	232%	1%
1.11. Бусад	18	3	0%	48	1	0%	75	17	0%	(1)	-48%	0%	16	0%	0%
2. Мал аж, ахуй		328	7%		293	7%		270	7%	(35)	-11%	-1%	(23)	-8%	-1%
2.1. Амьд мал, малын мах	2	6	0%	3	9	0%	5	12	0%	3	54%	0%	3	31%	0%
2.2. Арьс, шир	252	29	1%	262	26	1%	134	19	1%	(3)	-10%	0%	(7)	-28%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	7	0%	0	7	0%	0	5	0%	1	10%	0%	(3)	-34%	0%
2.4. Ноолуур	6	273	6%	6	233	6%	6	214	6%	(40)	-15%	-2%	(19)	-8%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	7	13	0%	11	17	0%	14	19	1%	4	31%	0%	2	14%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	1	0%	0	1	0%	0	175%	0%	1	149%	0%
3. Газар тариалан		18	0%		22	1%		16	0%	4	19%	0%	(6)	-27%	0%
I. Аж үйлдвэрлэл		161	3%		177	5%		271	7%	17	10%	0%	93	53%	2%
4.1. Хүнс	1	4	0%	3	17	0%	5	27	1%	12	282%	0%	11	64%	0%
4.2. Ноолууран эдлэл	1	20	0%	1	21	1%	1	21	1%	0	2%	0%	0	1%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	6	0%	1	8	0%	1	11	0%	2	33%	0%	4	46%	0%
4.4. Уул уурхай	15	39	1%	31	69	2%	25	70	2%	30	76%	1%	1	2%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	4	0%	0	2	0%	0	4	0%	(2)	-44%	0%	2	101%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эданги	2	80	2%	1	56	1%	1	129	3%	(24)	-30%	-1%	73	131%	2%
4.7. Бусад	183	7	0%	168	5	0%	190	7	0%	(2)	-27%	0%	2	37%	0%
5. Бусад		2	0%		2	0%		1	0%	(0)	0%	0%	(1)	-63%	0%
Нийт дүн		4,605			3,927			3,726		(678)	-15%		(200.5)	-5.1%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2016 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	500.6	-190%	(764.5)	290%	(263.9)	-8%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	122.6	-25%	(619.0)	125%	(496.5)	-26%
1.2. Чулуун нүүрс	228.8		(91.2)		137.6	29%
1.3. Боловсруулаагүй нефть	(2.2)	4%	(57.0)	96%	(59.2)	-18%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	53.3		(31.2)		22.1	12%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	60.2	68%	28.1	32%	88.3	25%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	25.7	151%	(8.6)	-51%	17.0	17%
1.7. Жоунш, лейцит, нефелинт	(6.1)	135%	1.6	-35%	(4.5)	-8%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3.1	-62%	(8.2)	162%	(5.0)	-20%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	(16)	52%	(1.5)	48%	(3.1)	-26%
1.10. Мөнгө /тонн/	10.9	46%	13.0	54%	23.9	232%
1.11. Бусад	6.0	39%	9.6	61%	15.6	0%
2. Мал аж, ахуй	(2.7)	12%	(20.0)	88%	(22.7)	-8%
2.2. Арьс, шир	(18.2)	250%	10.9	-150%	(7.3)	-28%
2.4. Ноолуур	6.0	-32%	(24.7)	132%	(18.8)	-8%
3. Газар тариалан	0.3	-5%	(6.2)	105%	(5.9)	-27%
4. Аж үйлдвэрлэл	(2.8)	-3%	96.1	103%	93.3	53%
5. Бусад	(0.3)	25%	(1.0)	75%	(1.3)	-63%
Нийт дүн	495.1		(695.7)		(200.5)	-5%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2016 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 495.1 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 695.7 сая ам.доллараар буурсан байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 500.6 сая ам.доллараар өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж 764.5 сая ам.доллараар буурснаас нийт дүнгээр 263.9 сая ам.доллараар буурлаа. Мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ буурснаас шалтгаалж 20.0 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 53%-иар буюу 93.3 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2016 оны 10 дугаар сард 1,266 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.3%-иар өссөн бол өнгөрсөн сараас 4.6%-иар буурчээ. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,732, 59 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 9%-иар буурч, төмрийн хүдэр 11%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 0.2%, 2.1%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 10 дугаар сард 41 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.1%-иар, өмнөх сараас 16.7%-иар тус тус өссөн.

Импорт 2016 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 12.5%-иар буюу 394.9 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 4 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)					
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²			
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,136	25%		907	29%		956	35%	(228)	-20%	-5%	49	5%	2%			
Түргэн эдэлгээтэй	678	616	14%	703	523	17%	688	522	19%	(93)	-15%	-2%	(1)	0%	0%			
Хүнс	327	430	10%	305	358	11%	321	360	13%	(71)	-17%	-2%	2	0%	0%			
Эм, пүриа	2	64	1%	2	61	2%	2	74	3%	(3)	-5%	0%	13	22%	0%			
Бусад түргэн эдэлгээтэй бараа	349	123	3%	396	103	3%	365	87	3%	(19)	-16%	0%	(16)	-15%	-1%			
Удаан эдэлгээтэй	149	520	12%	147	384	12%	108	434	16%	(135)	-26%	-3%	50	13%	2%			
Гутал, хувцас, цүнх	31	49	1%	35	42	1%	39	43	2%	(7)	-14%	0%	1	3%	0%			
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба твилаа	54	109	2%	65	75	2%	21	80	3%	(33)	-31%	-1%	5	7%	0%			
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	301	7%	1	213	7%	1	261	9%	(88)	-29%	-2%	47	22%	2%			
Бусад удаан эдэлгээтэй бараа	63	61	1%	46	54	2%	48	50	2%	(7)	-12%	0%	(4)	-8%	0%			
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		1,859	42%		1,220	39%		981	35%	(639)	-34%	-14%	(239)	-20%	-8%			
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	21	968	22%	15	628	20%	13	574	21%	(340)	-35%	-8%	(54)	-9%	-2%			
Суудлаас бусад твэрийн хэрэгсэл, эд анги	1	242	5%	1	94	3%	1	197	7%	(148)	-61%	-3%	103	110%	3%			
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	20	726	16%	15	534	17%	12	377	14%	(192)	-26%	-4%	(157)	-29%	-5%			
Барилгын материал	2,565	697	16%	1,568	429	14%	638	250	9%	(268)	-38%	-6%	(179)	-42%	-6%			
Хөрөнгө оруулалтын бусад бараа	95	195	4%	69	163	5%	46	157	6%	(32)	-16%	-1%	(6)	-4%	0%			
Аж үйлдвэрлэлийн орц		503	11%		428	14%		426	15%	(75)	-15%	-2%	(2)	0%	0%			
Хүнсний орц	56	30	1%	38	24	1%	185	51	2%	(6)	-21%	0%	27	115%	1%			
Химийн бүтээгдэхүүн	102	77	2%	105	75	2%	98	68	2%	(2)	-3%	0%	(7)	-9%	0%			
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	27	13	0%	15	13	0%	21	15	1%	(1)	-5%	0%	3	21%	0%			
Цахилгаан эрчим хүч	1	104	2%	1	106	3%	1	102	4%	2	2%	0%	(4)	-4%	0%			
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	1	0%	1	1	0%	1	100%	0%	0	42%	0%			
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалт ат	756	279	6%	663	211	7%	640	190	7%	(68)	-24%	-2%	(21)	-10%	-1%			
Нефтийн бүтээгдэхүүн		930	964	22%		931	588	19%		817	401	14%	(376)	-39%	-8%	(187)	-32%	-6%
Дизель түнш	545	537	12%	529	310	10%	413	184	7%	(226)	-42%	-5%	(126)	-41%	-4%			
АИ-92, АИ-95	255	272	6%	295	192	6%	264	129	5%	(81)	-30%	-2%	(63)	-33%	-2%			
А-80 болон бусад	131	155	3%	107	86	3%	140	87	3%	(69)	-45%	-2%	2	2%	0%			
Бусад		9	12	0%		17	20	1%		97	5	0%	8	0%	0%			
Нийт дүн		4,474		3,163		2,768		(1,311)	-29.3%	(394.9)	-12.5%							

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(13.6)		62.1		48.5	5%
Түргэн эдэлгээтэй	3.8	-328%	(5.0)	428%	(1.2)	0%
Удаан эдэлгээтэй	(17.5)	-35%	67.1	135%	49.7	13%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(326.6)	137%	87.9	-37%	(238.8)	-20%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(137.5)	256%	83.9	-156%	(53.6)	-9%
Барилгын материал	(187.6)	105%	8.4	-5%	(179.3)	-42%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(1.5)	25%	(4.4)	75%	(5.9)	-4%
Аж үйлдвэрлэлийн орц	36.0		(37.9)		(1.9)	0%
Нефтийн бүтээгдэхүүн	(46.7)	25%	(140.5)	75%	(187.2)	-32%
Дизель түнш	(51.8)	41%	(74.2)	59%	(125.9)	-41%
АИ-92, АИ-95	(15.3)	24%	(47.7)	76%	(63.0)	-33%
А-80 болон бусад	20.4	1133%	(18.6)	-1033%	1.8	2%
Бусад	3.8	-25%	(19.4)	125%	(15.6)	0%
Нийт дүн	(347.1)	88%	(47.8)	12%	(395)	-12%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2016 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 347 сая ам.доллараар буурчээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ буурсан хэдий ч үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 48.5 сая ам.доллараар өсчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 20%-иар буюу 238.8 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 32%-иар буюу 187.2 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 10-р сарын байдлаар тонн тутамд 527.8 ам.долларт хүрээд байна. Энэ нь өмнөх сараас 6 хувиар өссөн үзүүлэлт юм.